



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/455

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Экологийн боловсрол олгох зорилгоор "Жаргалант" хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх (Булган сум) төсөл, арга хэмжээний 1-р багц Зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан "ДАНСРАН ДҮВЧИН" ХХК -тай 53 300 000 (тавин гурван сая гурван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газар (Т.Баярбат)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Дансран дүвчин" ХХК -ийн захирал (Д.Энхжин)-д үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавихыг Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газар (Т.Баярбат)-т үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын санхүүжилтээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010582

Аймгийн Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 21-ны өдрийн
Ажлын дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Алтаншагай Т.Баярбат
2	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 30 хоног	Т.Баярбат